

Эрдэм шинжилгээний өгүүлэл
УДК 327(517.3+520)
DOI 10.18101/2949-1657-2025-1-40-49

Энэтхэг-номхон далайн бүс нутаг дахь япон улсын байр суурь, монгол, японы тусгай стратегийн түншлэл

© Баярсайхан Саранчимэг

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн,
Гуравдагч хөрш орон судлал салбарын Эрдэм шинжилгээний дэд ажилтан
Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Баруун сэлбэ 15, Улаанбаатар, 15170
saranchimeg_b@mas.ac.mn

Хураангуй. Тус өгүүлэлд Энэтхэг, Номхон далайн Стратеги хаанаас эхтэй, аль бүс нутагт өрнөж, улс орнуудын гадаад бодлогын үзэл баримтлалд хэрхэн тусгагдаж, байгаа талаар өгүүлнэ. Энэ нь Монгол Улсын Гуравдагч хөрш Япон улстай байгуулсан “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл” нь хоёр улсын харилцаанд хэрхэн нөлөөлөх, геополитикийн ширүүн өрсөлдөөн хил залгаа хөрш орон болон гуравдагч хөршийн хооронд өрнөж байгаатай холбогдуулан Монгол

Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын тэргүүлэх хоёр чиглэлд хамааралтай болохыг гаргаж ирэхийг зорилго.

Түлхүүр үгс: Энэтхэг-Номхон далайн стратеги, Чөлөөт, Нээлттэй Энэтхэг Номхон далай, Гуравдагч хөршийн бодлого, Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэл.

Ишлэл

Саранчимэг Б. Энэтхэг-номхон далайн бүс нутаг дахь япон улсын байр суурь, монгол, японы тусгай стратегийн түншлэл // Зүүн зүгийн вектор: түүх, нийгэм, улс. 2025; 1: 40–49.

Удиртгал: Япон улс сүүлийн жилүүдэд Америк-Японы холбоог улам бэхжүүлэхийн зэрэгцээ түнш орнуудтайгаа харилцаагаа өргөжүүлэн, Энэтхэг, Австрали орнуудтай нягт холбоог үүсгэж, Европын Холбоо, АСЕАН-ны орнуудтай дипломат харилцаагаа шинэ шатанд хүргэж, гадаад харилцаагаа тэлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. Шинзо Абэгийн үед гадаад бодлогодоо шинэчлэл хийснээс хойш Энэтхэг, Номхон далайн бүс нутаг гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болоод байна. Тэрээр Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх үзэл санааг дэвшүүлэн түүний ач холбогдлын талаар тунхаглан, “Чөлөөт, Нээлттэй Энэтхэг-Номхон далай” санаачлагыг гаргаж, Энэтхэг Номхон далайн стратеги бодлогын баримт бичиг боловсруулагдсанаар, тус бүс нутгийн ач холбогдол улам нэмэгдэж, стратегийн сөргөлдөөн ширүүсэж байна. Энэтхэг номхон далайн бүс нутагт ашиг сонирхол нэгтэй Их гүрнүүд нэгдэж, харилцан нэг нэгэндээ стратегийн сорилт буй нь, дэлхий нийтийг хамарч буй их гүрний өрсөлдөөн дунд хүчний тэнцвэрт нөлөөлөх стратегийн чухал түнш орон ч тодрон харагдаж байна.

Нийтлэг үнэт зүйлс бүхий улс орныг тус үзэл санаанд нэгтгэхэд чиглэсэн хамтын ажиллагаагаа 2022 онд Монгол улстай ч мөн эхлүүлсэн гэхэд болно.

Дэлхий нийтийг хамарсан стратегийн ач холбогдолтой, хүчний тэнцвэрт нөлөөлөхүйц, динамик шинжтэй чухал стратеги болох нь тодорхой юм.

Сүүлийн жилүүдэд Энэтхэг, Номхон далайн стратегийн талаарх сэдэв ГХЯ, судалгааны байгууллагуудад ихээр яригдаж, гадаад бодлогын чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн судлаач нар цухас дурддаг ч энэ талаар гүнзгийрүүлсэн судалгаа ховор байна. Энэтхэг, Номхон далайн стратеги нь АНУ-ын стратеги, Япон улсын гадаад бодлогын нэг хэсэг гэж үзсэн хэд хэдэн өгүүлэл, нийтлэлүүд байгаа. Энэтхэг, Номхон далайн бүс нутагт хамаарахгүй, далайд гарцгүй Монгол улсын хувьд энэ сэдэв хол хөндий мэт боловч Энэтхэг, Номхон далайн бүс нутагт хамтран ажиллахаар АНУ болон Япон улстай хамтран ажиллах тунхаглалаа зарлаад удаагүй байна. Мөн энэ чиглэлээр Америк, Япон, Монгол гурван талт хамтын ажиллагаагаа идэвхитэй явуулж эхлээд байна.

Их гүрнүүдийн хоорондын геополитикийн болон гео-эдийн засгийн стратегийн сөргөлдөөн нь Монгол улсын шууд хиллэдэг хоёр хөрш болон “Туравдагч хөрш”-ийн хооронд өрнөж байгаа нь Монгол Улс энэ огтолцлын цэгт байгааг тодоор харуулж байна. Иймээс Япон улсаас эхтэй тус бодлогын үзэл санаа, ач холбогдлыг Япон улсын алсан хараа, гадаад бодлоготой уялдуулан тайлбарлах, манай улсын Туравдагч хөршийн бодлогын үзэл баримтлал ямар хэрэгцээ шаардлагад тулгуурлан гарч ирсэн талаар эргэн харах нь, манай улстай юугаар харилцан хамааралтай болох нь илэрхий болохын хамт Энэтхэг Номхон далайн бүс нутагт чиглэсэн хамтын ажиллагаанд өөрийн гэсэн байр сууриа тодорхойлоход чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Нийтлэг үнэт зүйлс бүхий улс орнуудтай хамтрах, эгнээндээ нэгтгэх зорилго бүхий Япон улсын гадаад бодлогын “*Чөлөөт, нээлттэй, Энэтхэг, Номхон далай /FOIP/-*”н үзэл санаа буюу гэж чухам юм вэ?

2006 онд Гадаад харилцааны сайд асан ноён Таро Асо “*Эрх чөлөө ба хөгжил цэцэглэлтийн нум: Японы дипломат харилцааны хүрээг тэлэх нь*” семинарт тавьсан илтгэлдээ “*“Юуны өмнө бид дипломат үйл ажиллагаагаа урагшуулахын тулд ардчилал, эрх чөлөө, хүний эрх, хууль дээдлэх ёс, зах зээлийн эдийн засаг зэрэг “бүх нийтийн үнэт зүйлс”-ийг чухалчлан үздэг “үнэ цэнэд чиглэсэн дипломат ажиллагаа” юм. Хоёрдугаарт, Евразийн тивийн гадна захад нуман хэлбэртэй, амжилттай хөгжиж буй ардчилал бий. Энд Япон улс “Эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум”-ыг бий болгохыг эрмэлзэж байна. Үнэхээр бид ийм нум үүсгэх ёстой гэдэгт би итгэдэг*”¹ гэжээ. Тэрээр ийнхүү анх “*Эрх чөлөө ба хөгжил цэцэглэлт*”-ийн үзэл санааг дэвшүүлсэн.

Шинзо Абэ Японы Ерөнхий сайдаар 2006-2007 онд ажиллахдаа дөрвөн талт аюулгүй байдлын үзэл баримтлалыг эхлүүлж, Энэтхэг улстай нягт харилцаатай байхыг онцлон тэмдэглэсэн. Тэрээр 2007 онд Энэтхэгт хийсэн айлчлалынхаа үеэр Энэтхэгийн парламентын гишүүдэд хандан “*Хоёр тэнгисийн уулзвар*”² хэмээх илтгэлдээ “*Энэтхэгийн нээлт*” гэсэн үг бол бид Энэтхэгтэй ижил үнэт зүйл, ашиг сонирхлоо хуваалцдаг түнш мөн, бидэнтэй мөр зэрэгцэн хамтын ажиллагаагаа баяжуулах нөхөр гэдгээ дахин нээсэн гэсэн утгатай үг юм. Бүгдэд нээлттэй, ил

¹ Speech by Mr. Taro Aso, Minister for Foreign Affairs on the Occasion of the Japan Institute of International Affairs Seminar “Arc of Freedom and Prosperity: Japan’s Expanding Diplomatic Horizons”.

² URL: <https://worldjpn.net/documents/indices/FOIP/index-ENG.html>

тод байх эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн далай хийгээд “илүү өргөн Ази”-ийг дэмжихийн тулд Номхон далай болон Энэтхэгийн далайд нэгдэхийн чухлыг онцлон тэмдэглэж байв. Япон, Энэтхэг хоёр ингэж нэгдэн нийлснээр энэхүү “Өргөн Ази” нь Номхон далайг бүхэлд нь хамарсан, Америкийн Нэгдсэн Улс, Австрали улсыг багтаасан асар том сүлжээ болон хувирах болно. Шинэ газарзүй бий болно гэж төсөөлж, АНУ, Австрали, Энэтхэг улстай дөрвөн талт хамтын ажиллагааг улам ойртуулахыг уриалж байв.

Чухамдаа энэ илтгэл нь Энэтхэг-Номхон далайн бүс нутгийг хэрхэн төсөөлж болох тухай тодорхой бүтцийг олж нээсэн нь түүний тодорхойлсончлон “Трх чөлөө, хөгжил цэцэглэлтийн далай мэт динамик холбоо” юм. “Чөлөөт, Нээлттэй Энэтхэг-Номхон далайн бүс нутаг” гэгддэг “Эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум”-ыг сурталчилж, дөрвөлжингийн сүнс гэж тодорхойлсон стратегийг үргэлжлүүлэх нь Абэгийн энэхүү гадаад бодлогын үндэс бөгөөд “Абэгийн өв” юм.

2013 оны 1 дүгээр сарын 13-нд Жакартад болсон Япон- Индонезийн дээд хэмжээний уулзалтанд Шинзо Абэ “Нээлттэй тэнгисийн ашиг тус: Японы дипломат таван шинэ зарчим” илтгэлдээ “Японы үндэсний ашиг сонирхол бол Азийн далайг хоёрдмол утгагүй нээлттэй, эрх чөлөөтэй, энх тайван, хууль дээдлэх ёс бүрэн хэрэгжсэн дэлхийн бүх хүмүүсийн нийтлэг зүйл болгон хадгалахад мөнхөд оршдог. Дипломат хүчин чармайлтаа төвлөрүүлсэн эдгээр чиглэлүүдийн нэг бол АНУ-тай эвсэх явдал юм. Америк бол дэлхийн хамгийн том тэнгисийн цэргийн гүрэн бөгөөд эдийн засгийн хүчирхэг гүрэн; Япон бол Азийн хамгийн том далайн ардчилсан орон бөгөөд АНУ-ын дараа ордог либерал капиталист улс юм. Манай хоёр улс түнш байх ёстой гэсэн үндэслэлтэй. Өнөөдөр АНУ гол анхаарлаа Энэтхэг, Номхон далайн хоёр далай, бидний одоогийн байгаа бүс нутаг руу шилжүүлж байна. Ийм үед Япон-АНУ-ын холбоо урьд өмнөхөөсөө илүү чухал ач холбогдолтой болж байна. Аюулгүй байдал, хөгжил цэцэглэлт нь далайгаас хамааралтай Японы дипломат харилцааг төлөвшүүлсээр ирсэн хоёр чухал зорилтын хоёр дахь нь далайн Азитай харилцаагаа бэхжүүлэх явдал юм. Энэ хоёр их далай тайван нийлж, дэлхийн бүх хүмүүст үр өгөөжөө өгөхийн тулд одоо бид хоёр талын эвсэлд илүү их эрч хүчээ зориулж, түүнд илүү их үүрэг гүйцэтгэх цаг болсон гэдэгт би итгэж байна. Үүний тулд Япон улс өмнөхөөсөө илүү их хүчин чармайлт гаргаж, шинэ санаа, бүтээлч байдлыг бий болгох ёстой. Одооноос эхлэн Япон-АНУ-ын холбоо хоёр далайг хамарсан аюулгүй байдал, хөгжил цэцэглэлтийг хангах хангалттай өргөн сүлжээг бий болгох ёстой. Япон болон Америкийн бусад холбоотнууд болон түншүүдийн харилцаа Японы хувьд урьд өмнө байгаагүй чухал болно.” “Аюулгүй байдал, хөгжил цэцэглэлт нь далайгаас хамааралтай Японы дипломат харилцааг төлөвшүүлсээр ирсэн хоёр чухал зорилтын хоёр дахь нь далайн Азитай харилцаагаа бэхжүүлэх явдал юм”.¹Тэрээр илтгэлдээ энэ 2 зорилгоо хэрэгжүүлэхэд 5 шинэ зарчмаа танилцуулсан. “Нэгд, хоёр далай нийлдэг энэ бүс нутагт үзэл бодол, үг хэлэх эрх чөлөөг хамгаалах; Хоёрт, Далайг хүч хэрэглэх бус хууль дүрмээр зохицуулдаг болгох, дээрх хоёр зорилттой холбогдуулах Ази, Номхон далайн бүс нутаг дахь тэнцвэрийг сэргээх; Гуравт, Чөлөөт, нээлттэй

¹ The Bounty Of The Open Seas: Five New Principles For Japanese Diplomacy Address By H. E. Mr. Shinzo Abe, Prime Minister Of Japan January 18, 2013, Jakarta.

харилцан уялдаатай эдийн засгийг баримтлах, *Дөрөвт. Япон болон тус бүс нутгийн ард түмний хооронд үр өгөөжтэй соёлын харилцааг бий болгох; Тавд.: залуусын солилцоог дэмжих;*”¹ Тэрээр Энэтхэг-Номхон далайн үзэл санааг үр дүнд хүргэхийн тулд олон талаар идэвхтэй ажиллах, стратегийн хүрээгээ амжилттай өргөжүүлж, дипломат алсын хараатай болж, бүс нутаг дахь гол түншүүдийнхээ ойлголт, яриаг хэлэлцээг төлөвшүүлэхэд чиглэсэн дипломат ажиллагааг идэвхитэй хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд, 2016 оны 8-р сард Кени улсад болсон Африкийн хөгжлийн төлөөх Токиогийн олон улсын 6 дахь бага хуралд Абэ Чөлөөт, Нээлттэй Энэтхэг-Номхон далай /FOIP/-н үзэл баримтлал²-ыг “Номхон далай, Энэтхэгийн далай, Ази, Африкийг эрх чөлөө, хууль дээдлэх ёс, зах зээлийн эдийн засгийг дээдэлсэн, хүч хэрэглэхгүй газар болгон нийлүүлэх үүрэг хариуцлагыг баталгаажуулсан алсын хараатай стратеги гэж танилцуулж, албан ёсоор стратеги болгон дэвшүүлснээр энэхүү нэр томъёо олон улсын харилцаанд албан ёсоор нэвтэрч эхэлсэн. Үүний дараа 2017 онд АНУ-ын “Үндэсний аюулгүй байдлын стратеги” бодлогын баримт бичигт Ази, Номхон далайг Энэтхэг, номхон далай болгож бүс нутгийн нэгтмэл байдлыг илэрхийлсэн гадаад бодлогын чиглэл өөрчлөгдөв. 2019 онд АНУ-ын БХЯ-наас “*Энэтхэг, Номхон далайн стратеги*” бодлогын баримт бичиг гарснаар геополитийн орчинд нилээдгүй өөрчлөлт гарч, олон улс судлаач, геополитикчид Шинэ хүйтэн дайны эхлэл хэмээн тодорхойлов. Европын холбооноос Зүүн өмнөд Ази хүртэлх бүс нутгийн олон улс орнууд “*Энэтхэг-Номхон далайн стратеги*”-иа үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын баримт бичигт тусгаж байна.

АНУ-ын БХЯ-наас гаргасан “*Энэтхэг номхон далайн стратеги*” баримт бичигт Энэтхэг-Номхон далайн бүс нутагт явуулах бодлогыг тодорхойлж, Япон, БНСУ, Австрали, Филиппин, Тайланд улстай холбоотны харилцаагаа цаашид улам бэхжүүлэх нь чухал гэдгийг зааж, Ази, Номхон далайн бүс нутаг дахь стратегийн ач холбогдолтой улсуудыг нэрлэсэн байна. Тэдгээрийн тоонд Сингапур, Шинэ Зеланд, Монгол Улс болон Тайвань багтсан байна. Монгол Улс тус бүс нутгийн “*стратегийн түнш*” хэмээн тооцогдож байгаа эгзэгтэй үед маш богино хугацаанд түншлэлээ хоёр шатаар ахиулсан.

2018 онд Ухнаагийн Хүрэлсүх Ерөнхий сайдын албыг хашиж байхдаа АНУ-д албан ёсны айлчлал хийхдээ хоёр улсын “Өргөтгөсөн иж бүрэн стратегийн харилцаан” буюу шинэ түвшинд хүргэсэн. Уг айлчлалын үеэр АНУ Энэтхэг, номхон далайн бүс нутаг дахь Монгол улсын үүрэг, хувь нэмрийг ихийг тэмдэглэсэн байдаг. 2019 оны 7 дугаар сарын 29-нөөс 8 дугаар сарын 3-ны өдрүүдэд Ерөнхийлөгч Х.Баттулгын АНУ-д хийсэн ажлын айлчлалын үеэр гаргасан “Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын стратегийн түншлэлийн тухай тунхаглал” аар хоёр улсын харилцааг Өргөтгөсөн иж бүрэн стратегийн харилцаанаас Стратегийн түншлэлд дахин шинэ ахиулж 1 жилийн хугацаан хоёр дахин шат ахисан нь Монгол улсын геополитикийг үүрэг оролцоо нэмэгдэж буйг харуулж байна.

Хоёр улсын харилцаа Стратегийн түншлэлд хүрснийг зарлаж, хамтарсан тунхаглалдаа хоёр улсын хамтын эрмэлзлэл, харилцан сонирхол, нийтлэг зарчмыг заасан зургаан зүйлийг нотолж, цаашид хөгжүүлэх найман чиглэлийг

¹ Мөн тэнд.

² URL: <https://www.mofa.go.jp/files/000407643.pdf>

тодорхойлон тусгажээ. Тус найман чиглэлийн 2-рт “Энэтхэг- Номхон далайн бүс нутаг дахь нийт ард түмнүүдийн бүрэн эрхт байдлыг хангаж, олон улсын эрх зүй, шударга өрсөлдөөний зарчмуудад нийцсэн эдийн засгийн хөгжлийн боломжийг бүрдүүлэхийн тулд үндэсний аюулгүй болон тогтвортой байдлыг буй болгохын төлөө хамтран ажиллах” гэж хамтын эрмэлзлэлийг элэрхийлсэн байна.

АНУ-ын холбоотон гүрнүүдийн хамгийн ойрын холбоотон бол Япон улс. Япон улсын хувьд Америк-Японы аюулгүй байдлын гэрээ нь гадаад бодлогын тулгуур, Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн энх тайван, хөгжил цэцэглэлт нь гадаад бодлогын тулгын чулуу” гэж үздэг. Хоёр улс аюулгүй байдлын гэрээний дагуу батлан хамгаалах салбарт нягт хамтран ажилладаг. 2015 онд хоёр улсын батлан хамгаалах салбарт хамтран ажиллах удирдамжийг шинээр боловсруулсан. Үүнд “Японы энх тайван, аюулгүй байдлыг энхийн цагаас эхлээд гэнэтийн нөхцөл байдал хүртэл ямар ч нөхцөлд баталгаажуулж, Ази, Номхон далайн бүс нутаг болон цаашлаад тогтвортой, энх тайван, цэцэглэн хөгжсөн байдлыг дэмжихийн тулд хоёр талын аюулгүй байдал, батлан хамгаалахын хамтын ажиллагаа дараахь зүйлийг онцлон тэмдэглэнэ.

- саадгүй, бат бөх, уян хатан, үр дүнтэй хоёр талын хариу арга хэмжээ;
- хоёр улсын засгийн газрын үндэсний аюулгүй байдлын бодлогын хамтын ажиллагаа;
- засгийн газрын бүхэл бүтэн Холбооны арга барил;
- бүс нутгийн болон бусад түншүүд, түүнчлэн олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;
- бүс нутгийн аюулгүй байдалд Япон-АНУ-ын эвслийн үүргийг нэмэгдүүлэх”¹.

“Хоёр улсын засгийн газар Япон-АНУ-ын эвслийг тасралтгүй ахиулах болно. Засгийн газар бүр үндэсний аюулгүй байдлын бодлогодоо тулгуурлан бие даасан батлан хамгаалах байр сууриа хадгална. Япон улс “Үндэсний аюулгүй байдлын стратеги” болон “Үндэсний батлан хамгаалах хөтөлбөрийн үндсэн чиглэл”-ийн үндсэн дээр батлан хамгаалах чадавхийг эзэмшинэ. АНУ Японд бүх хүчин чадлаараа, тэр дундаа АНУ-ын цөмийн зэвсэгт хүчин чадлаараа саатуулах арга хэмжээгээ үргэлжлүүлэх болно. АНУ мөн Ази, Номхон далайн бүс нутагт байлдааны бэлэн хүчээ байршуулж, эдгээр хүчийг түргэн шуурхай бэхжүүлэх чадавхийг хадгалах болно.”² АНУ-Японы холбоотон гүрний хувьд Аюулгүй байдлын гэрээг шинэчилж, батлан хамгаалах салбартаа хамтран ажиллах удирдамжинд салхи оруулсан нь нэг алсын хараа, нэг бодлого чиглэлтэй, нэгэн зэрэг Энэтхэг Номхон далайн бүс нутгийн зүг хараагаа чиглүүлэхэд хүргэжээ.

Япон улс “Үндэсний батлан хамгаалах стратеги(NSS)” баримт бичгийг 2022 оны 12 сарын 16-нд шинэчилэгдэн батлагдсан тус баримт бичигт “Монгол Улс нь газарзүйн хувьд Хятад, Оросын дунд орших стратегийн ач холбогдол бүхий ардчилсан орон. Энэ үүднээс Япон улс батлан хамгаалахын техник, технологийн хамтын ажиллагааг ахиулж, бүх түвшинд батлан хамгаалах солилцоо, чадавхийг бэхжүүлэх, олон талт сургуулилт хийхээс гадна улс төр, аюулгүй байдлын

¹ The Guidelines for Japan-U.S. Defense Cooperation April 27, 2015.

² Мөн тэнд.

салбарын хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах болно.”¹ Гэдгээ тус баримт бичигт тусгасан байна. Тус баримт бичиг боловсруулснаа зарлахын өмнөхөн 2022 оны 11-р сарын 29-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, Япон Улсын Ерөнхий сайд асан Фүмио Кишида нар албан ёсны хэлэлцээ хийж, хэлэлцээний үр дүнгээр Монгол Улс, Япон Улс хоорондын харилцааг цаашид улам бэхжүүлэхийн зэрэгцээ цаашдын хамтын ажиллагааны хүрээнд бүс нутаг, олон улсын тавцанд хоёр улс тус тусдаа хамтын ажиллагааг бэхжүүлэхийг зорилго болгон-ийг байгуулж, хамтран ажиллах 10 жилийн замын зураглалыг гаргасан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хоёр улс дараах 4 үндсэн чиглэлд хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн өргөжүүлэхээр тогтсон байна. Үүнд:

1. Улс төр, аюулгүй байдал.
2. Эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа.
3. “Хүн төвтэй” хөгжил, иргэд хоорондын харилцан солилцоо.
4. Дэлхий нийтийг хамарсан нийтлэг асуудлаарх хамтын ажиллагаа.

Монгол, Япон хоёр улс 1972 онд дипломат харилцаа тогтоосноос хойш *Иж бүрэн түншлэлийн харилцаа (1996-2010)*, *Стратегийн түншлэлийн харилцаа (2010-2022)* хөгжүүлж ирэв. Манай улс 2010 оноос хойш Япон улстай хөгжүүлсэн Стратегийн түншлэлийн харилцааг шат ахиулж 2022 онд “*Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэл*” байгуулсан явдал түүхэн чухал алхам болсон юм. Энэ нь хоёр улсын улс төрийн харилцан итгэлцэл жилээс жилд улам бүр бэхжиж дээд, өндөр түвшний харилцан айлчлалууд амжилттай хэрэгжсэний баталгаа юм. Манай хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны чиг шугам, зураглалыг тодорхойлдог Монгол, Японы Стратегийн түншлэлийн Дүнд хугацааны хөтөлбөр (2013-2017), (2017-2021)-үүдийг амжилттай хэрэгжүүлж дуусгасан. Үүнтэй залгуулан 2022 онд байгуулсан шат ахиулсан явдал түншлэлийн нэр томъёо агуулгын талаасаа ч үнэт зүйлд суурилсан харилцаа гэхээсээ илүү хоёр улсын харилцаа геополитикийн чухал үүрэг оролцоотой хамтран ажиллах төлөвтэй байна.

Мөн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Токио хотноо Япон Улс, Монгол Улс болон АНУ-ын гурван талт уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтад Японы Гадаад хэргийн яамны Ази, Номхон далайн газрын Ерөнхий захирал Такэхиро Фүнакоши, Монгол Улсын Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н. Анхбаяр, АНУ-ын Төрийн Департаментын Япон, БНСУ, Австрали, Шинэ Зеланд, Номхон далайн арлууд хариуцсан Туслах ТНБД-ын орлогч Марк Ламберт нар оролцжээ. Гурван тал хамтын ашиг сонирхол, нийтлэг үнэт зүйлсийн төлөө бүс нутгийн аюулгүй байдлын тулгамдсан асуудал, эдийн засгийн асуудал, хамтын ажиллагааны чиглэлийг өргөн хүрээнд авч хэлэлцэв. Гурван тал бие биетэйгээ нягт харилцаатай байх, Энэтхэг-Номхон далайн бүсийг чөлөөтэй, нээлттэй байлгах үзэл баримтлалдаа үнэнч байхаа дахин нотлов. Япон Улс болон АНУ нь Монгол Улсын ардчилал, гуравдагч хөршийн бодлогыг дэмжихээ илэрхийлсэн. Энэ дэлхий нийтийг хамарсан нийтлэг асуудлаарх хамтын ажиллагаанд нухацтай хандах цаг болсныг сануулж байгаа бөгөөд Монгол Улсын хувьд Гуравдагч хөршийн бодлогын хэрэгцээ, шаардлага анх урган гарсан хүчин зүйл юу вэ гэдгийг эргэн харахад хүрч байна.

¹ National Defense Strategy December 16, 2022.

Монгол улс 1990-ээд оноос хойш үндэсний эрх ашигт нийцсэн олон тулгуурт гадаад бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргасны үр дүнд 1994 онд Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалдаа олон тулгуурт гадаад бодлогыг дараах үндсэн 6 чиглэлээр хэрэгжүүлнэ хэмээн баталсан. Үүнд:

1. Хоёр хөрштэй харилцах бодлого.
2. Өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай харилцах бодлого.
3. Азийн бодлого.
4. Олон улсын байгууллагуудтай харилцах бодлого.
5. Хуучин социалист гэгдэж байсан улсуудтай харилцах бодлого.
6. Хөгжиж байгаа орнуудтай харилцах бодлого.

Чухамдаа энэхүү 6 тэргүүлэх чиглэл нь олон тулгуур болж, Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах хүчин зүйл болно гэж судлаачид үздэг. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий улс орнууд, бүс нутгуудын улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг Монголд бий болгож, тэдгээр ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх замаар Монгол улсын гадаад, дотоод аюулгүй байдлыг зарим нэг талаар хангах боломжтой юм гэж үздэгээс үүдэн Монгол Улс хоёр хөршөөс гадна стратегийн ач холбогдол бүхий улс орон, бүс нутгууд буюу “гуравдахь түнш” орнуудын эрэлд гарсан байдаг. Эдүгээ тэдгээр орныг “Гуравдагч хөрш” хэмээн нэршээд байна. Монгол улс хоёрхон хөрштэй хил залгаа, жижиг орны хувьд гуравдахь түншийн асуудал чухлаар тавигдах нь зүй ёсны хэрэг. “Гуравдагч хөрш хэмээх энэхүү стратегийн үзэл баримтлал нь улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, соёлын бүрдэл хэсгүүдийг өөртөө агуулдаг. Үндсэндээ энэ нь АНУ, Герман, Япон зэрэг бусад хүчирхэг орнууд Монголын шууд хиллэдэг хоёр хөрштэйгөө хийх харилцаанд тэнцвэржүүлэгчийн үүрэг гүйцэтгэх тухай ойлголт юм”¹.

“Хэдийгээр Монгол Улс нь хүн ам, эдийн засаг, цэрэг армийн хувьд жижиг улс боловч газарзүйн өвөрмөц байршил нь улс төрийн хувьд АНУ төдийгүй бүс нутгийн бараг бүх улс орны анхаарлыг татдаг” гэж Алиша Кэмпи² “Гуравдагч хөрш орны эрэлд”³ өгүүлэлдээ онцлон тэмдэглэсэн байна. Профессор Норихико Икэда “Монгол Улс дэлхийн улс орнуудтай харилцахдаа зөвхөн Орос, Хятадын буфер улс биш олон улсын хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүн гэсэн үндэслэлд тулгуурлан харилцаагаа бэхжүүлэхийг хүсдэг. Энэхүү аргумент нь хэдийгээр үндэслэлтэй боловч бусад улсууд Монгол Улсыг энэхүү үнэлэмжээр хүлээн зөвшөөрч хүлээн авдаг уу гэдэг нь тодорхойгүй юм” хэмээн үзжээ. Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Х. Олзвой⁴ “Олон улсын харилцаан дахь гуравдахь түншлэлийн зарим асуудал” өгүүлэлдээ “Монгол улстай дорвитой түншлэн ажиллаж чадахуйц улс гүрнүүд АНУ-аас гадна хэд хэд байна. Үүнд, юуны өмнө манай орны ардчилсан шинэчлэлийг эхнээс нь дэмжсэн Япон Улсыг нэрлэх нь

¹ Монголын гадаад бодлого.УБ хот., 2020 он. Алиша Кэмпи, “Гуравдагч хөршийн эрэлд” 31-р тал.

² Жонс-Хопкинсийн Олон улсын харилцааны сургуулийн Азийн тэнхимийн дэд профессор, “Монгол Нийгэмлэг”-ийн Ерөнхийлөгч, доктор, дэд профессор.

³ Мөн тэнд, 31-р тал.

⁴ Монголын дипломат, төрийн зүтгэлтэн. 1990-1994 онд Гадаад яамны орлогч сайд, 1994–1996 онд БНХАУ-д суусан Элчин сайд. Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин дипломат цол 1991 онд хүртсэн.

зүй. Япон Улс нь Азийн Хөгжлийн банк, Дэлхийн Банктай адил Монгол Улсын хамгийн гол хандивлагч билээ.”¹ ... “Иймд шашин нэгтэй, түүхийн хувьд холбоотой явж ирсэн Азийн нэгэн их гүрэн Япон нь нөхцөл бүрэлдээд ирэх цагт манай улсын бас нэгэн “Гуравдахь хөрш” болох магадлал бий гэж үзнэ.”² хэмээн 20-иод жилийн өмнө онцолж байжээ. 2011 онд шинэчлэн найруулсан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд “АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” хэмээн заасан. Монгол Улс уг бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өндөр хөгжилтэй орнуудтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлжнээр АНУ, Япон улсын ашиг сонирхлыг өөрийн оронд бий болгож чаджээ. Гуравдагч хөрштэйгээ түншлэлээ ахиулсан явдал нь Монгол Улсын хувьд гуравдагч хөршийн бодлогоо идэвхитэй хэрэгжүүлсний үр дүн, нөгөөтэйгүүр гуравдагч хөршийн нүдээр Ази тивийн цээжинд “Ардчилал, эрх чөлөөний бамбар” мэт гэрэлтэж, хоёр гүрний дунд хавчуулагдсан далайд гарцгүй газар зүйн онцлог бүхий “Ардчилал эрх чөлөөний арал” гэмээр тодоос тод анхаарал татаж буй нь их гүрнүүдийн гадаад бодлогод татагдан орж байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Дүгнэлт

Монгол Улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий Америк, Япон зэрэг улс орнууд улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг Монголд бий болгох нь Монгол улсын гадаад, дотоод аюулгүй байдлыг зарим нэг талаар хангах боломжтой гэж зарим судлаачид үздэг ч гуравдагч хөршийн бодлогыг 2011 онд шинэчлэн найруулснаас хойш геополитикийн орчин нөхцөл өөрчлөгсөнийг харгалзан үзэх, Монгол улс далайд гарцгүй тус бүс нутагт хамаарагдахгүй боловч өрсөлдөөний гол талбар болж буй Энэтхэг, Номхон далайд баримтлах өөрийн гэсэн бодлого, байр суурийг улс суурьтай тодорхойлох, эрсдэл боломжийг тооцоолох цаг иржээ.

Япон-АНУ-ын холбоо нь Японы дипломат бодлого, аюулгүй байдлын тулгын чулуу бөгөөд бүс нутаг, олон улсын энх тайван, хөгжил цэцэглэлтэд чухал үүрэг гүйцэтгэсээр байна. “Чөлөөт, нээлттэй Энэтхэг-Номхон далайн бүс”-ийг хадгалах, дэмжих чиглэлээр нягт хамтран ажиллаж байгаа нь Япон-АНУ-ын холбоо урьд өмнөхөөсөө илүү чухал болгож байна.

Японы дипломат ажиллагаа олон улсын хамтын ажиллагааны зарчимд суурилсан “Энх тайванд идэвхтэй хувь нэмэр” бодлогын хүрээнд дэлхийн газрын зургийг панорама талаас нь авч үзвэл дипломат харилцааг өндөр түвшинд хүргэж байна. Япон улс геополитикийн өрсөлдөөний эрин үед эрх ашгаа хамгаалж, Чөлөөт, Нээлттэй, Энэтхэг, Номхон далайн стратегийн хүрээгээ амжилттай өргөжүүлж, системээ цаашид нэгтгэж, дипломат алсын хараагаа урагшлуулах бүс нутаг дахь гол түншүүдийнхээ ойлголт, яриаг төлөвшүүлэх чухал алхам нь Тусгай стратегийн түншлэлийн үндэс суурийг бэхжүүлэх явдал нь юм. Энэ утгаараа хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэл” нь үнэт зүйлд суурилсан “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн

¹ Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба гурав дахь түнш орнууд: Өнөө, ирээдүй. УБ хот. 2002 он. 25-р тал.

² Мөн тэнд. 26-р тал.

нумыг байгуулах” алсын хараа бэлгэдсэн стратегийн ач холбоцолтой эхлэл тавигдлаа гэж үзэж байна.

Ашигласан материал

1. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал. 2011 он. URL: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203362>.
2. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жил. Улаанбаатар, 2014 он.
3. Монголын гадаад бодлого ба Монголын геополитик. Удирдлагын академи. 2018 он.
4. Б. Баасансүрэн. Орос, Хятадын завсар дахь Монгол Улс. Их эрсдэл сорилтууд, эвтэй боломжууд. Улаанбаатар, 2014.
5. Р. Болд “Туравдагч хөршийн бодлого”: Зарим эргэцүүлэл. XX зууны Монгол: Түүх, соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд. Улаанбаатар, 2017
6. Монгол улсын гадаад бодлогын зангилаа асуудлууд. Хөгжлийн бодлогын судалгааны хүрээлэн. Улаанбаатар, 2020 он.
7. Монголын гадаад бодлого. Өөрчлөн шинэчлэгдэж буй дэлхийг залуурдах нь Алиша Кэмп. Улаанбаатар, 2020.
8. Монгол улсын XX зууны гадаад бодлогын түүхэн тойм. МУИС. Олон улсын харилцааны сургууль. М.Дүгэрсүрэн. Ц.Гомбосүрэн. Улаанбаатар, 2004 он.
9. Монгол улсын үндэсний аюулгүй байдал ба гурав дахь түнш орнууд: өнөө, ирээдүй. Улаанбаатар, 2002.
10. “АНУ-ын Энэтхэг-Номхон далайн стратеги” 2021.10.08. URL: <https://niss.gov.mn/archives/2360>
11. “Ж.Байдены Энэтхэг-Номхон далайн шинэ стратеги” 2022.02.25. URL: <https://niss.gov.mn/archives/2518>.
12. Ц. Буянцогтоо, О. Үржин “Энэтхэг-Номхон далайн стратегийн хүрээнд Америк-Оросын харилцаанд гарч болзошгүй өөрчлөлтийг шинжлэх нь” (ОУСС Vol.44 № /112/2021)
13. Д. Золбоо, Л. Бямбаханд Энэтхэг-Номхон далайн бүс дэх АНУ-ын гадаад бодлого ба Монгол Улс, АНУ-ын стратегийн түншлэл” (Олон Улс Судлал №1 (110), 2020 он) DOI: <https://doi.org/10.5564/jis.v1i110.1339>
14. <https://doi.org/10.5564/jis.v44i112.1615>
15. The Bounty Of The Open Seas:Five New Principles For Japanese Diplomacy Address By H.E. Mr. Shinzo Abe, Prime Minister Of Japan January 18, 2013, Jakarta. https://www.mofa.go.jp/announce/pm/abe/abe_0118e.html
16. Speech by Mr. Taro Aso, Minister for Foreign Affairs on the Occasion of the Japan Institute of International Affairs Seminar “Arc of Freedom and Prosperity: Japan’s Expanding Diplomatic Horizons”. URL: <https://www.mofa.go.jp/policy/pillar/index.html>
17. National Security Strategy of the United States of America. December 2017. URL: [https://en.wikipedia.org/wiki/National_Security_Strategy_\(United_States\)](https://en.wikipedia.org/wiki/National_Security_Strategy_(United_States))
18. Indo PacificStrategy report June1
19. National Security Strategy (NSS) December 16, 2022. URL: https://www.mofa.go.jp/fp/nsp/page1we_000081.html
- National Defence Strategy of Japan December 16, 2022. URL: https://www.mofa.go.jp/fp/nsp/page1we_000082.html
20. The Guidelines for Japan-U.S. Defense Cooperation April 27, 2015. URL: <https://www.mofa.go.jp/files/000078188.pdf>

Нийтлэлийг 2025 оны 3-н сарын 16 өдөр редактор хүлээн авсан; хянан үзээд 2025 3 сарын 30 өдөр баталсан; 2025 4-нд сарын 28-нд өдөр хэвлүүлэхээр хүлээн зөвшөөрсөн.

Б. Саранчимэг. Энэтхэг-номхон далайн бүс нутаг дахь япон улсын байр суурь, монгол, японы тусгай стратегийн түншлэл

Japan's Position in the Indo-Pacific Region
and the Special Strategic Partnership Between Mongolia and Japan

Bayarsaikhan Saranchimeg

Researcher,

Third Neighbor Studies Department, Institute of International Studies, MAS

15 Baruum Selbe St., 4th Khoroo, Chingeltei District, 15170 Ulaanbaatar

saranchimeg_b@mas.ac.mn

Abstract. The article examines the origins of the Indo-Pacific Strategy, the regions where it is being implemented, and how it is reflected in the foreign policy concepts of various countries. It focuses on the “Agreement on Peace and Prosperity” signed with Mongolia’s “third neighbor” — Japan. The article's aim is to highlight how the “Special Strategic Partnership” will influence bilateral relations and its significance for the two main directions of Mongolia’s foreign policy in the context of intense geopolitical competition between neighboring and third-party countries.

Keywords: Indo-Pacific Strategy, free and open Indo-Pacific, Third Neighbor Policy, Special Strategic Partnership for Peace and Prosperity.

For citation

Saranchimeg B. Japan's Position in the Indo-Pacific Region and the Special Strategic Partnership Between Mongolia and Japan. *Oriental Vector: History, Society, State*. 2025; 1: 40–49 (In Mong.).

The article was submitted 16.03.2025; approved after review 30.03.2025; accepted for publication 28.04.2025.